

6.ХУУЛЬ, ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН(Ж-Х-3-2.2)

УИХ, Засгийн газрын тогтоол , тэмдэглэлийг оны тухай бүр нь хяналтанд авч холбогдох хэлтэс, агентлаг , албан тушаалтанд хариуцуулан өгч, биелэлтийг улирал бүр тооцож Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллаа. 2009 онд нийт 136 шийдвэрийн 205 заалтыг хяналтанд авч биелэлтийг гаргахад 100% хэрэгжсэн 95 заалт,90% хэрэгжсэн 60 заалт, 70% хэрэгжсэн 16 заалт, 50% хэрэгжсэн 12 заалт, 30% хэрэгжсэн 10 заалт, 10% хэрэгжсэн 8 заалт байна. Нийт тогтоол шийдвэрийн дундач хувь **89.9** хувьтай байна. Өнгөрсөн оноос 94 тогтоолын 158 заалтыг нэхэн шинээр нэмж хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

А.Засгийн газрын тогтоолын хэрэгжилт

2009 онд Засгийн газрын 132 тогтоолын 197 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тогтоолын нийт заалтын 100% хэрэгжсэн 89 заалт, 90% хэрэгжсэн 58 заалт, 70% хэрэгжсэн 16 заалт, 50% хэрэгжсэн 12 заалт, 30% хэрэгжсэн 10 заалт, 10% хэрэгжсэн 8 заалт байна. Нийт тогтоолын дундач хувь **82.3** хувьтай байна. Өнгөрсөн оноос 93 тогтоолын 155 заалтыг нэхэн шинээр нэмж хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Б.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

2009 онд Засгийн газрын хуралдааны 4 тэмдэглэлийн 8 заалтыг хяналтанд авч хэрэгжилт нь 97.5 хувьтай байна